



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1108

Даланзадгад сум

Ёс зүйн дэд хороо шинэчлэн
байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Байгууллагын дотоод журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хамт олны хурал болон 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар олонхын санал авсан нэр бүхий албан хаагчдаас Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, гишүүдийг хавсралтаар байгуулсугай.

2. Төрийн албан хаагчид үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ЖАВЗАНДУЛАМ



462501088

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
А/08 дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЕС ЗҮЙН
ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Гишүүд:

Б.Амгалан

(Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга)

Б.Оюунсүрэн

(Хяналт, шалгалтын хэлтсийн эрүүл ахуй халдвар
хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Ганшагай

(Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга)

Б.Цагаанцэнд

(Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга)

Б.Бямбажав

(Нийгмийн эрүүл мэндийн төвийн Халдварт өвчний
асуудал хариуцсан мэргэжилтэн)

оОо